

Гэр оронгүй тэнэмэл амьдралыг рациональ сонголтын онолоор тайлбарлах нь

Лхагвасүрэнгийн Баянмөнх 

*Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн
Нийгмийн ухааны тэнхийн докторант, Монгол улс, Улаанбаатар.*

Төмөрчөдөрийн Сүмжидмаа 

*Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн Менежментийн сургуулийн
Технологийн менежментийн тэнхимийн дэд профессор, Монгол улс, Улаанбаатар.*

Сүхбатын Туяа 

*Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн дэд профессор, Монгол улс, Улаанбаатар.*

Хүлээн авсан - Received:
2025-04-06

Засварласан - Revised:
2025-05-02

Хэвлэгдсэн - Published:
2025-06-10

babukaa2022@gmail.com

ORCID: [0000-0002-2233-7929](https://orcid.org/0000-0002-2233-7929)

sumjidmaa@must.edu.mn

ORCID: [0000-0001-5002-4164](https://orcid.org/0000-0001-5002-4164)

s.tuya@must.edu.mn

ORCID: [0000-0001-7337-5530](https://orcid.org/0000-0001-7337-5530)

Corresponding author:
Tuяa Sukhbat



© 2025, Author(s)

Хураангуй: Гэр оронгүй тэнэмэлээр амьдрах нь дэлхий нийтийн хэмжээнд өсөн нэмэгдэж буй нийгмийн томоохон асуудлын нэг бөгөөд Монгол улсад ч мөн сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд ихээхэн хурцадмал болж байна. 2022 оны байдлаар нийслэлд бүртгэгдсэн гэр оронгүй иргэдийн тоо 3200 бөгөөд бодит тоо үүнээс ч өндөр байж болзошгүйг албаны зүгээс мэдэгдэж байгаа юм. Гэр оронгүй тэнэмэл амьдрал нь ажилгүйдэл ядуурал, архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, орон нутгаас шилжин ирсэн зэрэг эрсдэлт хүчин зүйлээс шалтгаалж байгаа тухай өмнөх судалгаануудын үр дүн харуулдаг. Бид энэхүү судалгаагаар өдөр ирэх тутам өсөж нэмэгдэж, залуужсаар байгаа гэр оронгүй байдал нь хувь хүмүүсийн өөрсдийн сонголт, “өвөрмөц соёл” болон өөрчлөгдөж байна хэмээн үзлээ. Гудамж, талбай зэрэг нийтийн эзэмшлийн орон зай, орц хонгил, гол горхи бараадан амьдрах иргэд гэр бүлээсээ тусгаарлагдсан, олон жил тэнүүчлэн амьдарч байгаа нь судалгаагаар “хувь хүний өөрийн сонголт” буюу өөрийн дураар эрх чөлөөтэй амьдрах эсвэл хувиа хичээсэн зан төлөв давамгайлсан нөхцөл байдлыг үүсгэсэн болохыг илэрхийлж байна. Энэхүү өгүүлэлд Улаанбаатар хотын хэмжээнд гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг байршуулан үйлчилгээ хүргэж буй 7 төвийн 30 иргэнийг оролцуулан хүүрнэн өгүүлэх ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулан судалж, үр дүнг хураангуйлан хүргэлээ.

Түлхүүр үг: Хувь хүний сонголт, орон гэргүй, тэнэмэл иргэд, зан төлөв, эрх танхи, эрх чөлөө

1. ОРШИЛ

Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн¹ гэх ойлголт 1990 оны нийгэм, эдийн засгийн шилжилтийн үеэс хойш нийгмийн томоохон асуудал болон газар авсаар байна. Тухайн үедээ ядуурал, хүчирхийлэл, ажилгүйдлээс үүдэлтэй нийгмийн бүтцийн хямралаас улбаалан гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд,

¹ Европын холбооноос 1993 онд гаргасан нийгмийн тухай актад амьдрах гэр орон байхгүй эсвэл ямар нэг хаяггүй, нийтийн эзэмшлийн гудамж талбайд, орон сууцны зориулалтын бус байранд хоноглодог тохиолдолд тухайн иргэнийг орон гэргүй хэмээн үзсэн байдаг (Boróka Fehér, *Understanding the Homeless Experience in Hungary through a Narrative Approach*, 2011). Түүнчлэн Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8, 18.2.8-р зүйлд зааснаар гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй байдаг.

гуйлга гуйсан хүмүүс олширч “тэнэмэл”, “траншейны”, “вагоны хүүхдүүд”, “өвгөнтийн хөндийн” зэрэг шинэ бүлгийг үүсгэж байсан бол өдгөө нэмэгдсээр, тэдэнд тусалж дэмжлэг үзүүлэх түр хоноглох төвүүд, нийгмийн халамжийн үйлчилгээ тэлсээр байна.

Гэсэн хэдий ч нийгмийн бугшмал болж буй энэхүү асуудлын хариу үйлчилгээ болгон Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.8, 18.8, 18.5, 18.6, 20.1.1, 20.2.4, 20.5, 22.1.2, 21.1.1- 21.1.2 заалтаар сургалт, зөвлөгөө, сэргээн засах, түр байрлуулан асрамжлах, хамгаалах, өдрийн үйлчилгээ, хүүхдүүдэд хичээлийн хэрэгслэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт, хүнс тэжээл, эрүүл мэндийн зэрэг бие махбод, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээг хэрэгжүүлдэг. Нийгмийн халамжийн хэлтсийн судалгаагаар 2018 онд гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн тоо 1375 байсан бол (АХБ, 2019) Нийслэлийн халамжийн газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Нийслэлийн Нийгмийн хамгааллын тусгай төв, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтарсан судалгаагаар гэр оронгүй, тэнэмэл амьдралтай, архины хамааралтай иргэдийн тоо 2020 оны байдлаар 850 иргэн байгааг тогтоон мэдээллийн санд бүртгэжээ (Эрдэнэчимэг Ө, 2024). Тэнэмэл амьдралтай иргэдийн тоо буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа боловч мэргэжилтнүүдийн үзэж буйгаар бүртгэгдээгүй, албан ёсны тоонд ороогүй олон иргэд байгааг тодорхойлж байна. Хүйсийн хувьд эдгээр иргэдийн 91 хувь нь эрэгтэй бөгөөд жил ирэх тусам насны хувьд залуужсаар байгаа юм. Дэлхий нийтийн өмнө шийдвэрлэгдэж чадахгүй хүрээгээ тэлсээр бодлогын шийдэл, интервенцийг хэрхэн оновчтой үр дүнтэй хэрэгжүүлэх вэ гэдэг асуулт судалгааны хүрээнд ч их тавигдаж байна.

Гэр оронгүй байдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг функционализм, бүтэц үүргийн онол, Бэлгэдэлт харилцан үйлдлийн онол, Нийгмээс тусгаарлах хандлагад тайлбарласнаар нийгмийн тогтолцооны гажуудал, орон сууцны хүрэлцээгүй байдал, хөдөлмөрийн зах зээл зэрэг үйл ажиллагааны доголдол, гэр бүлийн хүчирхийлэл, ядуурал, ажилгүйдэл, сэтгэцийн эмгэг, донтолт, гаж зан үйлийн зэрэг хувь хүн, гэр бүлийн нөлөөллүүдийг нотолсоор байна. Гэр оронгүй байх нь хэвийн бус үзэгдэл бөгөөд өртөж буй иргэдийг эмчлэх, сэтгэл зүйн гэмтлийг эдгээх, нийгэмшүүлж нийгэмд эргэн нэгтгэх зайлшгүй шаардлагатай. Олон учир шалтгааны үр дагавартай, нарийн төвөгтэй үзэгдэл учраас өртөж байгаа хувь хүнийг хамгаалах, тэр дундаа эмчилгээ, нөхөн сэргээх тусламж хяналтыг хүргэж, нийгмийн эв нэгдэл, итгэлцэл, сайн сайхан байдал, гэмт хэрэг, ёс суртахууны уналт гажуудлаас хамгаалах ач тустай.

Рациональ сонголт гэдэг нь эдийн засаг болон нийгмийн шинжлэх ухаанд хүний шийдвэр гаргалтыг “өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн хамгийн үр ашигтай хувилбарыг сонгодог” хэмээх онолын ойлголт юм. Тэгэхээр гэр оронгүй тэнэмэл амьдрах нь рациональ сонголтын үр дүн мөн үү? гэсэн асуулт тавигдах нь зүй. Өөрөөр хэлбэл, орон гэргүй байх нь гажуудсан зан авир эсвэл асуудалтай эмгэгээс үүдэлтэй сонголт гэхээсээ илүү "хэвийн" мөн чанарыг эрхэмлэх хувийн хүсэл эрмэлзэлийн илэрхийлэл (Parsell, 2012) хэмээх хандлага нэмэгдсээр байна.

2. Сэдвийн судлагдсан байдлын тойм

Энэхүү сэдвээр олон улсын түвшинд хийсэн судалгаа нэлээдгүй байх ба үндэсний хэмжээнд хийсэн судалгаа байхгүй байна. Тэр бүү хэл гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийн талаарх статистик тоон мэдээлэл зөрүүтэй, олон улсын түвшинд авч үздэг Гэр оронгүй хүн гэж хэнийг тодорхойлох тухай асуудлыг цэгцлэх шаардлагатай. Бидний судалгаандаа “Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэн” хэмээн Нийгмийн халамжийн тухай хуулинд заасан ойлголтыг энд авч үзсэн. Гэр оронгүй иргэдийг түр хамгаалах төв энэ хуулийг зохицуулалтаар өдгөө үйлчлүүлэгчдийг байршуулан үйлчилгээг хүргэсээр байна. Энэ төв нь хүний анхдагч хэрэгцээ болох унтаж амрах, халуун хоол хүнс, хувцас, өдөр тутмын эд зүйлээр хангахаас гадна халуун ус, угаалгын газар, сэтгэл зүйн зөвлөгөө авах, эрүүл мэндийг хамгаалах зэрэг нийгмийн үйлчилгээтэй холбогдох гол газар юм. Гэвч гэр оронгүй амьдралаар амьдарч байгаа дийлэнхи иргэд хамгаалах байрыг ашиглах боломжтой ч тэндээ үлдэхгүй байх сонголтыг хийж байна (Klor, 2018). Энэ нь хамгаалах байр ачаалал ихтэй, цаг хугацаа, хүчин чармайлт их шаарддаг, хэтэрхий завгүй, стресс, тааламжгүй байх, хүн хулгайлах, хүчирхийлэлд өртөх эрсдэл, хүмүүсийг засан хүмүүжүүлэхэд хэтэрхий их анхаардаг, хүүхэд мэт хандах, эцэг эхийн арга барилтай, хүний нэр төр, бие даасан байдлаа хадгалахаас

татгалзахад хүргэх, үйлчилгээний ажилтнуудын үл хүндэтгэл, биелээгүй амлалт өгөх зэрэг шалтгаантай холбоотой хэмээн үзжээ. Мөн зарим нь хамгаалах байрны дүрэм журам, тогтолцоог дарамт хэмээн үзэж, урхинд орсон (Bond, 2022) мэтээр хүлээж авдаг байна. Архи ууж, тамхи хэрэглэхээ болих, байрны сахилгын дүрмийг зөрчвөл хөөгдөх магадлалтай ба бодлого, дүрэм журмыг дагаж мөрдөхөд зарцуулсан хүчин чармайлыг төдийлөн үнэлдэггүй хэмээн үзсэн судалгааны үр дүнгүүд бий. Тиймээс гэр оронгүй иргэдэд хүргэх үйлчилгээ, хөтөлбөрүүдийн амжилт нь тухайн үйлчилгээг ашиглах хувь хүний хүсэл эрмэлзлээс хамаарах (Patterson, 2013) болдог.

Онолын хандлагаар орон гэргүйдэл нь тодорхой нөхцөлд хувь хүний ухамсартайгаар хийсэн сонголт байж болзошгүй боловч зарим судлаачдын зүгээс нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатайг тодотгодог юм. Зарим хүмүүс уламжлалт амьдралын хэв маягаас татгалзаж, чөлөөт хязгааргүй амьдралыг эрхэмлэж болно. Түүнчлэн тэдний хувьд орон гэргүй амьдрал нь бие даасан байдал, хариуцлагаас зайлсхийх эсвэл бүтээлч, өөр хэв маягаар амьдрах хүсэл байж болно хэмээн уг онолчид үздэг.

Гэр оронгүй тэнэмэл байдлыг хувь хүний сонголт хэмээх үзэл эртнийх бөгөөд одоог хүртэл гажуудсан зан үйл, эмгэг асуудлын маргааныг дагуулсаар байдаг (Parsell, 2012) хэмээн тайлбарлаж, орон гэргүй хүмүүсийн сонголтод нөлөөлөх, амьдралыг утга учиртай болгодог зарим нөхцөл байдлыг судалж, өөрсдийн хувь нэмрийг оруулсан байна. Гэр оронгүй хүн гэж хэнийг хэлэх вэ? гэсэн олон улсын тодорхойлолтуудад амьдралын хүнд нөхцөл байдал, нийгмийн тогтолцооны хямрал, ажилгүйдэлтэй холбон үздэг нь дийлэнх бол рациональ онолын үүднээс гэр оронгүй байхыг хувь хүн өөрөө сонгосон байж болно гэсэн таамаглалыг дэвшүүлдэг. Энэ утгаараа хувь хүний шийдвэр, сонголт хэмээн үзэх нь өргөн хүрээнд тархсан гэдгийг нотолсон судалгааны ажлууд багагүй байна (Blackman, 1998). Өөрөөр хэлбэл, гэр оронгүй иргэдийн талаарх энэхүү үзэл баримтлалыг судлаачид, улс төрчид хүлээн зөвшөөрдөг аж. Тухайлбал АНУ-ын Ерөнхийлөгч асан Р. Рейган “гэр оронгүй байдал бол сонголт хэмээн бид хэлнэ” (Wright, 1989) гэсэн бол Английн Ерөнхий сайд (John Major) “гэр оронгүй байдал бол сонголт” (Jones, 1997) Австралийн үндэсний эвслийн намын сөрөг хүчний удирдагч Тони Эбботт (Tony Abbott) “Ядууралд өртсөн хүмүүс үргэлж бидэнтэй хамт байх бөгөөд харин орон гэргүй байхыг сонгосон хүмүүсийн төлөө засгийн газраас хийх чадах зүйл бараг байдаггүй” (Perusco, 2010) хэмээн тус тус мэдэгдэж байжээ. Эдгээрээс харвал гэр оронгүй байдлыг хувь хүний сонголт, ёс суртахууны асуудалтай холбон нийгмийн хамгааллын бодлого, үйлчилгээний төрөл хэлбэртээ тусгах шаардлага тулгардаг аж. Иймээс эдгээр иргэдэд энэ байдлыг харгалзан үйлчилгээ, кейс менежментийг хүргэдэг байна. Рациональ сонголт хэмээх ойлголт нь сүүлийн үед судалгаа болон нийгмийн хамгааллын үйлчилгээнд чухал ойлголтын нэг болоод байна. Тухайлбал 1979 онд J.Ward “The Street is there Home: The Hobos” бүтээлдээ гэр оронгүй байдал нь урт хугацааны үйлчилгээг орхисон хувь хүний ухамсартай сонголт (J.Ward, 2010) хэмээсэн бол Jordan Going Bad: Homeless Men in an Aistralian City бүтээлдээ “хүмүүст гэр оронгүй байдлыг сонгодог хоёр хувилбар байна, нэгд, муу зүйлийг сонгож өөрсдийгөө ялдаг бол хоёрт тэд ухаалгаар гэвч энэ нь ёс суртахуунгүй сонголт” (Jordan, 1994) гэсэн дүгнэлтийг хийжээ. Түүнчлэн тав тухтай, эсвэл хязгаарлагдмал тайван амьдралыг сонгож байгаа үйл явц бөгөөд хүсээгүй зүйлээс зайлсхийж, “өөрийгөө эргэцүүлэн бодох, эрх чөлөөт амьдрал” (Wasserman, 2010) гэх хандлага ч гарч ирсэн. Мөн судлаач Coleman Австралийн гэр оронгүй иргэдийн дунд хийсэн судалгаандаа “гэр оронгүй олон нийт” (homeless community) хэмээх ойлголтыг хэрэглэсэн бөгөөд судалгаанд оролцогчид хотын гудамж, цэцэрлэгт хүрээлэнг өөрийн гэр орон мэтээр мэдрэн амьдарч байгааг (A.Coleman, 2000) илрүүлсэн юм. Дэлхий дахинаа энэ мэтчилэн гэр оронгүй байдал, ядуурлыг таслан зогсоох судалгаа, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ч үзэгдэл буурахгүй улам бүр нэмэгдэж хүрээгээ тэлсээр байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл “амьдралын хэв маяг-(lifestyle)”, хувь хүний эрх чөлөө -(personal freedom) -ний илэрхийлэл нь гэр оронгүй байх сонголт гэсэн өнцгийг судлаачид онцолжээ. Иймэрхүү үзэл баримтлал нь асуудлаа даван туулах стратегийг шинээр боловсруулах тухайлбал гэр оронгүй иргэдийг гудамжинд “гэртээ байгаа” байдлаар байрлуулах, тусламж дэмжлэг, халамжийн үйлчилгээний хэлбэрүүд шаардлагатайг харуулж байгаа юм. Халуун хоолны үйлчилгээ, эмнэлэгийн тусламж үйлчилгээг тэдний төвлөрч байгаа “халуун цэг”-т хүргэх ажил манай улсад ч аль хэдийнээ бий

болж, тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгэмд хор хөнөөлтэй үйлдэл хийхийг хязгаарлах сайн туршлага их байна.

Судлаач Rubenstein орон гэргүй болох нь албан ёсны хөдөлмөрийн зах зээлд оролцох хүсэлгүй, хувийн сахилга баттай холбоотой хүлээгдэж буй хэм хэмжээг дагаж мөрдөхгүй байх хувь хүний сонголт (Rubenstein, 1992) гэж үзсэн. Мөн 2007 онд Batterham Австралын 3000 оролцогчийг хамруулсан үндэсний хэмжээний судалгааны үр дүнд үндэслэн гэр оронгүй болох нь архи, согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээ, буруу шийдвэр гаргасны үр дагавар (Batterham, 2009) гэжээ. Тэрээр үнэхээр хэрэгтэй байгаа учраас тэд гудамжинд байна, зарим хүмүүсийн хувьд сэтгэцийн эрүүл мэнд, сахилга батгүй, өөрийгөө хүндэтгэдэггүй, гаж зан байдлаас улбаатай сонголт бөгөөд хүлээгдэж буй зүйлсийг хийх хүсэлгүй, ёс суртахуунгүй сонголтууд нь гэр оронгүй байдалд хүргэдэг гэдгийг анхааруулсан юм. Англи, Австрали зэрэг улс орнууд нийгмийн хамгааллын бодлогоо эдгээр таамаглал, үр дүнд тулгуурлан боловсруулж, санаатайгаар гэр оронгүй болоогүй гэдгээ нотолж чадах “гудамжны” хүмүүст тусламж дэмжлэг үзүүлэх заалтыг хуулиндаа тусгаж байжээ. Австралийн Гэр оронгүй хүмүүсийн тухай хуулинд “зарим хүмүүсийн сонголт” хэмээх заалтыг оруулж, хувь хүмүүс өөрсдийн нөхцөл байдлын талаар ямар ч хязгаарлалтгүй сонголт хийх боломжтой гэсэн дүгнэлтийг хийж байжээ.

Sara Brallier, Stephanie Southworth нарын гэр оронгүй иргэд түр хамгаалах байрыг ашиглах эсэхээ хэрхэн шийддэг болохыг шинжлэх зорилгоор Өмнөд Каролина мужийн Миртл Вич - (Myrtle Beach) хотын гэр оронгүй 44 оролцогчийг (16 эмэгтэй, 28 эрэгтэй, 6 фокус) хамруулсан судалгааг явуулсан байна. Судалгааны үр дүнгээс харвал оролцогчид бүгд нэг буюу хэд хэдэн удаа хамгаалах байранд очсон ба байр нь тохитой, хүртээмжтэй, аюулгүй, цэвэрхэн байвал дахин очих болно гэдгээ илэрхийлжээ. Гэвч түр хамгаалах байр нь хангалттай ор хэрэгсэлгүй, шаардлагатай үйлчилгээ үзүүлээгүй, аюулгүй, цэвэрхэн эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хамгаалах байрны ажилтнууд үл хүндэтгэсэн, зүй бус харьцсан нь нөлөөлж гардаг (Sara Brallier, 2024) гэсэн хариултыг өгч байв. Хамгаалах байрны системээс боломжтой үйлчилгээг авахаас татгалзаж үл тоомсорлох, тэдэнд зориулсан хөтөлбөрөөс зайлсхийх нь “гудамж”-ийг ухаалгаар сонгож байгаа зүйл үү? гэсэн асуудлыг хөндөж, хувь хүнд төвлөрсөн судалгааны ажил чухал байгааг сануулсан юм.

3. Судалгааны арга зүй

Бид уг судалгааны мэдээллийг чанарын судалгааны арга зүйг ашигласан ба гэр оронгүй иргэдийг нийгэмшүүлэх, туслах дэмжих зорилготой төрийн болон төрийн бус байгууллагын 7 төвийн 30 үйлчлүүлэгчээс ганцаарчилсан ярилцлага авсан. Мэдээлэл цуглуулахад ярилцлагыг үндсэн арга болгосон төдийгүй баримт бичгийн судалгааны аргыг ашиглалаа. Цуглуулсан мэдээллийг гэр оронгүй тэнэмэл нөхцөл байдалд хүргэсэн хүчин зүйлсийн хувь хүний, гэр бүл, нийгмийн гэсэн ангиллаар хуваан тематик шинжилгээ хийж нэгтгэн дүгнэсэн болно.

4. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Рациональ сонголтын онолыг Америкийн сэтгэл зүйч Уильям Глассер боловсруулсан бөгөөд хүний зан үйл, сонголт, шийдвэр гаргалтын харилцан хамаарлыг тайлбарладаг юм. Онолын гол үзэл санаа нь хүн өөрийн амьдралын хяналтыг гартаа авч, ухамсартай сонголт хийх замаар хүссэн амьдралаа бүтээх боломжтой гэсэн ойлголтод тулгуурладаг. Нийгмийн нөхцөл байдал, хувь хүний үйл хөдлөлийн аль алинд нь үндэслэн үр дүнг урьдчилан тооцож хийх сонголт гэсэн утгаар Жеймс С.Колмэн, М.Вебэр нарын судлаачид онолыг цааш нь баяжуулсан (Нарантулга Б, 2022). Энэхүү онол нь зарим хүмүүс үндэслэлгүй мэт санагдаж болох сонголтыг яагаад хийдэг болохыг ойлгоход тусалдаг. Хэдийгээр нөхцөл байдлаас гадна хэн нэгэн хүний шийдвэрийг ойлгохгүй байж болох ч тухайн хүний хувьд оновчтой гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болох үе байна. Энэ үед нийгмийн үйлчилгээг оновчтой хүргэх, зардал үр ашгийг үр дүнтэй хуваарилахад ч энэ нь ашигтай байж болохыг судлаачид тэмдэглэж байна (Parsell, 2012).

Рациональ сонголтын онол ба орон гэргүй байдал

Рациональ сонголтын онол нь хүний зан төлөвийг ойлгоход ашиглагддаг аргуудын нэг юм. Энэхүү хандлага нь эдийн засагт зонхилох парадигм байсаар ирсэн ч социологи, улс төр, антропологи зэрэг салбаруудад ч өргөн хэрэглэгдэх болсон байна. Рациональ сонголтын онол нь хувь хүн өөрийн ашиг сонирхолд нийцсэн хамгийн үр өгөөжтэй шийдвэрийг гаргана хэмээн үздэг (Scott, 2000) болохыг өмнө дурьдсан. Өөрөөр хэлбэл хүмүүс өөрт буй бүх сонголтыг харьцуулан хамгийн ашигтайг эсвэл хувиа хичээсэн зан үйл давамгайлсан нөхцөл байдлыг сонгох (Helmut Bester, 1998) ёстой болдог. Тэгэхээр манай улсад нэгэнтээ нийгмийн томоохон үр дагаварыг бий болгож ужигарсаар байгаа гэр оронгүй амьдрал (Эрдэнэчимэг Ө, 2024) нь рациональ сонголт уу?

Нийгмийн хамгааллын тусгай төвийн тодорхойлсноор “орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэд гэдэг нь бусдын хүчирхийлэл, бусдын дарамт, санаандгүй үйлдэл болон өөрийн буруутай үйлдлийн улмаас байрны орц, хонгил, траншейд сүүлийн нэг сар амьдарч байгаа тэжээн тэтгэх гэр бүл, төрөл садангүй эсвэл тэдгээр нь дэмжлэг тусалцаа үзүүлэхээс татгалзсан хүн”²-ийг хэлнэ. Тодорхойлолтод тусгаснаар зарим нөхцөлд хувь хүн хүчирхийлэлтэй байх, хойд эцэг эхтэй байх, эсвэл гэр бүлийн гишүүд нь архины хамааралтай зэргээс дайжих нөхцөл үүсэж байна. Энэ нөхцөлд хүчирхийлэлтэй орчинд амьдрах уу, хүчирхийлэлтэй орчноос дайжин зугтах уу гэдэг сонголт гарч ирэх боломжтой юм. Гудамжинд гарч гэр оронгүй өөрийн эрх дураар байх, эсвэл түр хамгаалах байранд амьдрах гэх мэтээр хүчирхийлэл, хүчирхийлэл бүхий орчноос зугтах арга замуудын сонголт гарч магадгүй. Гэвч олонхи тохиолдолд гэр оронгүй явах нь тэдний хүссэн сонголт биш, энэ тохиолдолд хүчээр хийгдсэн шийдвэр болж байгааг хэлэх хэрэгтэй. Нөгөө талаас хэт хайр халамж буюу бэрхшээлийг даван туулах чадвар сул тухайлбал, Монголчуудын хувьд эрэгтэй хүүхдээ хэтэрхий их дээдлэн хайрлаж голомт залгах отгон, ганц гэх мэтээр буруу эрхлүүлэн эрх танхи өсгөх нь амьдралын бэрхшээл, сорилтын үед шийдвэр гаргах, даван туулах, эрсдлийг тооцоолох чадваргүй, хариуцлагын мэдрэмж султай, эцэг эхээс, хэн нэгнээс үргэлж хамааралтай байх, ямар ч үед өрөвдүүлэн хайрлуулах хэрэгцээгээ бусдаас хүсэмжилж байдаг нь сэтгэл гутралд орох, архины хамааралтай болох, улмаар гэр бүлийн байдал тогтворгүй, орон гэргүй болох эрсдлийг (Баянмөнх. Л, 2023) бий болгож байна.

Нийгмийн хамгааллын тусгай төвийн мэдээллээр Улаанбаатар хотын хэмжээнд 2024 онд нийт 800 иргэн үйлчлүүлж кейс хаасан ба үүнээс анх удаа ирж байгаа үйлчлүүлэгч 452 байжээ. Гэр оронгүй иргэдийг нийгэмшүүлэх тэднийг бие даасан амьдралд шилжихэд туслах дэмжих зорилготой төрийн болон 10 гаруй төрийн бус байгууллага үйлчилгээг хүргэж байна. Тэдгээрээс Улаанбаатар хотын хэмжээнд үйлчилгээ хүргэж буй 7 байгууллагын 30 үйлчлүүлэгчээс авсан ганцаарчилсан ярилцлагаар гэр оронгүй тэнэмэл нөхцөл байдалд хүргэсэн хүчин зүйлсийг хувь хүний, гэр бүл, нийгмийн гэсэн ангиллаар хуваан тематик шинжилгээ хийж үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 1-ээс харна уу).

Хүснэгт 1. Гэр оронгүй тэнэмэл амьдралд ороход нөлөөлж буй хүчин зүйл

Хувь хүний хүчин зүйл	Гэр бүлийн хүчин зүйл	Нийгмийн хүчин зүйл
1. Багаасаа тэнэх дуртай болсон	1. Эцэг эхийн хараа хяналт сул	1. Ажлын байр хаагдсан
2. Сургууль завсардалт	2. Эцэг эх асран хамгаалагчгүй	2. Орлогын эх үүсвэргүй
3. Сурах сонирхолгүй	3. Хотод ирээд өөрийн гэсэн гэр оронгүй	
4. Архины хамааралтай болсон	4. Ахуйн архидалт	
5. Гаж буруу зуршил, хулгай хийх гэх мэт зуршилтай болсон	5. Гэр бүлийн хүчирхийлэл	
6. Эрх чөлөөтэй бие даан амьдрах хүсэл давамгайлсан	6. Хойд эцэг эхийн дарамт, зодуур	
7. Сэтгэл санаа тогтворгүй байдалтай болсон	7. Гэр бүлийн маргаан зөрчил	
8. Өөртөө итгэлгүй байдал үүссэн		
9. Бусдаас хамааралгүй эрх дураар байх сонирхолтой		

² <https://nhht.ub.gov.mn/>

10. Айлын эрх танхи хүүхэд болон өсөх	8. Гэр орон шатсан	
11. Харилцааны ур чадваргүй, хүмүүсийн шаардлага хүлээн авдаггүй	9. Асрамжийн газарт нас бие хүрээд гарсан	
12. Ажил хийж сураагүй	10. Эцэг эх нас барсан	
13. Ажилдаа тогтворгүй байнга солих, удаан ажиллах хүсэлгүй	11. Орон гэрээ зарсан	

Судалгаанд оролцогчдын 43.3% нь хувь хүний хүчин зүйлээс хамааран гэр оронгүй тэнэмэл байдлаар амьдрахыг сонгон шийдвэр гаргажээ. Энэ нь хүүхэд наснаасаа эхлэн тэнэх, сургуульд сурах сонирхолгүй, гаж буруу зуршлуудад автсан, сэтгэл санааны тогтворгүй байдал үүссэн, харилцааны ур чадвар сул, “үг даах” ажлын ачаалал даах чадваргүй эрх танхи өссөн, өөрийн эрх чөлөөг эрхэмлэсэн буюу “хувиа хичээх” үзэл хандлага зэргээс хамаарч байна.

Код 301 – эмэгтэй, 46 настай: “Эмээ өвөөгийн эрх хүүхэд байсан. Нөхрийн дарамт, хадмуудын харилцаа л ийм болгосон. Хадам ах, хадам ээж 2 их нөлөөлсөн гэж боддог. 1998 онд нөхрөөсөө шууд зугтаж, ганцаараа гудамжинд гараад л явсан, 2 хоног яваад юм ч олж идээгүй, өлсөөд цангаад, орцонд хоносон. Эмэгтэй хүн их дарамтлуулаад ирэхээр шийдвэр их хурдан гаргадаг юм билээ”.

Код 1001- эрэгтэй, 36 настай: “Аав, ах, эгч, дүү нартайгаа амьдардаг байсан. Тодорхой хэмжээний найз нөхөд байсан. Харуул жижгүүрийн ажил хийдэг байсан. Гэнэт л гадуур явмаар санагдаад сэтгэл санаа тогтворгүй, архи ууж эхэлсэн. Ингээд л гудамжинд амьдарч дураараа байх нь илүү санагдаж эхэлсэн”.

Код 217- эрэгтэй, 32 настай: “Орон нутагт төрийн албанд ажилладаг байсан. Айлын 3 хүүхдийн том ах. Гэр бүлийн харилцаа их сайн байсан. Эрх дураараа өссөн. Дэлгүүр ажиллуулдаг байсан болохоор тэндээ худалдагчаа хийдэг байсан. Найз нөхөд, ах нар орж ирэхээр тамхи өгчихдөг, тэд ч архи зээлж уудаг байсан. Ах нар архидаж байхдаа дуудаж уулгадаг, “энэ их хоншоортой бацаан” гээд хөөргөддөг байлаа. Архинд ороход наргиж цэнгэх дуртай байдал их нөлөөлсөн. Архи уухаар зориг их ордог байсан. Архинд орсоноор гэр бүлээс холдож Улаанбаатар хотод ирснээр өөрийн гэсэн гэргүй гудамжаар амьдрах болсон”.

Код 208 – эрэгтэй, 37 настай: “Ээж аавын харилцаа хэвийн байсан ч аав архи их уудаг байсан. Ээжийг байхгүй хойгуур гар өргүүлж зогсоож шийтгэдэг, зоддог гэх мэтээр. Том ах шоронгоор явсан, танхай хүн байв. Манайх сансарт байранд амьдардаг байсан. 8 наснаасаа хойш тэнэж эхэлсэн, Кристина Нобел, Энхтайвны салхи гэх мэт асрамжаар их явсан. Гэр бүлийн хүчирхийлэл сэтгэл санааны байдалд их нөлөөлсөн гэж боддог. Эргээд гэртээ очихыг хүссэн ч айдаг байсан. Гэртээ очсон ч гудамжны амьдралаа үгүйлээд эргээд гардаг байв. Эрх чөлөөтэй, дураараа явах нь дээр, бие даах хүсэл ч их байсан”.

Харин гэр бүлийн таагүй хүнд нөхцөл байдлыг даван туулах, эцэг эх нас барж, асран хамгаалагчгүй үлдсэн, асрамж халамжийн төвөөс гарсан, архины хамааралтай болж гэр бүлийн маргаан, хүчирхийлэл даамжирч салалтаар төгссөн, өөрийн гэсэн орох оронгүй болсон зэрэг шалтгаанаар тухайн газрыг орхин очих газаргүй гудамжинд гарах нь дараагийн нэг хүчин зүйл болж байна.

Код 700 – эрэгтэй, 41 настай: “Миний архинд орсон гол шалтгаан нь дүүтэйгээ хамт архи уудаг байсан, эхнэрээсээ салсан, мөн дараалан ойр дотны хүмүүсээ алдсан зэргээс болсон гэж боддог. Бас би өөрөө сэтгэл санаагаар унасан, дахин босох сэтгэлийн тэнхээгүй зэрэг нөлөөлсөн байх гэж бодож байна”.

Код 308 - эмэгтэй, 40 настай: “4 настайдаа хойд аавтай болсон. Бага насандаа их дарамтанд өссөн. Иймээс 8 наснаасаа гадуур тэнэдэг болсон. Ээж ажилдаа явчихдаг хойгуур хойд аав золбин гэж дуудаад өөрийнх нь хүүхдийг уйллуулаа гээд л зоддог байсан. Аав архи уудаг, мөрийтэй тоглодог байсан. Одоо ч ээж аав 2 намайг траншейных гээд л дууддаг. 2001 онд нөхөртэй болж 2 хүүхэд гаргасан. 2004 оноос их уудаг болж томыгоо ээжид үлдээгээд нөгөө

охиныг аав нь аваад би гудамжинд гарсан. Хүнд гай болохгүй амьдаръя гээд л гэрээс гараад явсан. Өөрийн орон гэргүй хүн чинь хаа сайгүй л амьдарч эхэлсэн. Архины хамааралтай ч болсон, хямдхан архи уухгүй, өөрийнхөө олсон мөнгөөр ууж байна гэх мэтээр өөрийгөө өмөөрдөг байсан. 2008 оноос л жинхэнэ “шуудай үүрээд” архины мөнгө л олох гэж гудамжинд тэнээд явдаг болсон”.

Нийгмээс хамаарсан хүчин зүйл харьцангуй бага, хувь хүний болон гэр бүлээс шалтгаалсан хүчин зүйлс давамгайлж байгаа нь эдгээр хүмүүс “гэр оронгүй” тэнэмэл байдлаар амьдрах нөхцлийг өөрсдийн шийдвэрээр сонгож байгаа зураглал харагдаж байгаа юм.

ДҮГНЭЛТ

Гэр оронгүй тэнэмэл амьдралтай иргэдийг гэр бүл, нийгэмд эргэн нэгтгэх нь нэлээд төвөгтэй, үйлчилгээний дараа ч тэд “халуун цэг” рүүгээ эргэсээр байгаа шалтгааныг нийгэм эдийн засгийн талаасаа ядуурал, ажилгүйдэл, орон сууцны хүртээмжгүй байдал, гэр бүлийн хүчирхийлэл, таагүй нөхцөл байдалтай холбон тайлбарлах нь түгээмэл байдаг. Гэвч хувь хүний сонголт биш үү? гэх хандлага ч анхаарал татаж байна. Учир нь Улаанбаатар хотын хэмжээнд түр хоноглох төвд амьдарч буй иргэдийг архи, согтууруулах ундааны хамаарлаас гаргах, хэвийн аж амьдралаар амьдрахад бэрхшээлтэй хэвээр, улмаар шинэ үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсээр байгаа юм. Хүйтний улирал эхлэхэд төвд дулаахан, хоол ундтай, эм эмнэлэгийн болон бусад үйлчилгээг авч өвлийг өнгөрүүлдэг бол урин дулаан орох 3 сараас дийлэнх нь төвийг орхин гудамж, траншей, орц хонгилоор дахин тэнүүчлэн амьдрах сонголтыг хийж байгаа нь тухайн хүний төвд байх хугацаанд хүртэж байсан үйлчилгээг үр дүнгүй болгож байна. Тэдэнд хүргэж буй төвүүдийн үйлчилгээ, санхүүгийн зардлын үр ашиг, хөтөлбөрүүдийн амжилт нь тухайн үйлчилгээг ашиглаж байгаа хувь хүний хүсэл эрмэлзэл ямар түвшинд байгаагаас хамаарч байна. Төвийн үйлчилгээ, амьдралын энгийн хэв маягаас татгалзаж, хувийн эрх чөлөөт байдал, дүрэм журмын дагуу хариуцлага хүлээн амьдрахаас зайлсхийх хандлагатай байна. Архины бүрэн хамааралтай байдал ч үүнд их нөлөөтэй. Хувь хүний болон гэр бүл, нийгмийн шалтгаантай нөхцөл байдлаасаа хамаарч өөрийн ашиг сонирхолд нийцсэн, өөрт хамгийн ашигтай болох “гудамжинд амьдрах” шийдвэрийг гаргаж байна. Түр хоноглох байраар үйлчлүүлж буй иргэдийн 40 гаруй хувь нь гэр оронгүй тэнэмэл амьдралыг “хувь хүний өөрийн сонголт”-оор хийсэн гэж үзсэн нь энэхүү үзэгдэл нь тухайн хүнээс эсвэл гэр бүлийн байдлаас хамаарсан СОНГОЛТ УУ эсвэл нийгэм эдийн засаг, уламжлал, амьдралын хэв маяг, соёлын хүчин зүйлийн НӨЛӨӨ ЮУ, гэдгийг нарийвчлан судлах шаардлага байгааг илэрхийлж байна. Гэр оронгүйдлийн шалтгааныг “сонголт” эсвэл “нөлөө”-д үндэслэн судлах нь тэдэнд чиглэсэн нийгмийн ажлын тохиромжтой үйлчилгээг хэрэгжүүлэх, тэднийг нийгэмд эргэн нэгдэх боломж, арга замыг тодорхойлох нэг шийдэл болно гэж үзэж байна.

An explanation of homelessness through the rational choice theory

Bayanmunkh Lkhagvasuren 

Doctoral student, Department of Social Science, School of Humanities and Social Sciences. Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia.

Sumjidmaa Tumurchudur 

Associate Professor, Department of Technology Management, School of Management. Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia.

Tuya Sukhbat 

Associate Professor, Department of Social Science, School of Humanities and Social Sciences. Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia.

Abstract:

Homelessness is one of the major and increasingly widespread social issues worldwide, and in Mongolia, it has also become particularly acute over the past few decades, especially in Ulaanbaatar. As of 2022, the official number of registered homeless individuals in the capital city was 3,200, although authorities acknowledge that the actual figure may be even higher. Previous studies have shown that homelessness is driven by risk factors such as unemployment, poverty, alcoholism, domestic violence, and migration from rural areas. This study argues, however, that homelessness—which is growing and becoming younger each year—has also been transforming into a matter of individual choice and a form of “unique culture.” Research findings indicate that individuals residing in public spaces such as streets, squares, apartment entrances, and riverbanks, who have been separated from their families and wandering for many years, often reflect a situation shaped by “personal choice,” in which freedom to live independently or self-centered attitudes prevail. This article presents summarized research findings from narrative interviews conducted with 30 individuals residing in seven centers that provide shelter and services for homeless people in Ulaanbaatar.

Keywords: *personal choice, homelessness, vagrants, behavior, self-indulgence, freedom*

Ном зүй

- A.Coleman. (2000). Five star motels: Spaces, places and Homelessness in Fortitude Valley, Brisbane. The university of Queensland, st.Lucia.
- ADB. (2021). *A Study on Homelessness In Mongolia*.
- Batterham, D. (2009). Understanding Public Perceptions and Attitudes to Homelessness in Australia. *Melbourne: Hanover Welfare Services*.
- Blackman, S. (1998). Disposable generation?: An ethnographic study of youth homelessness in Kent. *Youth & Policy Issue*, 59, 38-56.
- Bond, L. W. (2022). Weighing the options: Service user perspectives on homeless outreach services. *Qualitative Social Work*, 21 (1), 177-193.
- J.Ward. (2010). *The Street Is There Home: The Hobos*. Melbourne: Quarter Books.: Melbourne: Quarter Books.
- Jones, G. (1997). Youth homelessness and the underclass. in: R. Masdonal. *Youth, the Underclass and Exclusion*, 96-112.
- Jordan, A. (1994). *Going Bad: Homeless Men in an Australian City*. Victoria.
- Klop, H. T.-P. (2018). Care avoidance among homeless people and access to care: an interview study among spiritual caregivers, street pastors, homeless outreach workers and formerly. *BMC Public Health*, 18, 1-12.
- Parsell, C. P. (2012, Mar 06). Homelessness as a Choice. *Housing, Theory and Society Volume 29*, Volume 29, Issue 4. Retrieved from Housing, Theory and Society: <https://doi.org/10.1080/14036096.2012.667834>
- Patterson, M. L. (2013). Exiting homelessness: Perceived changes, barriers, and facilitators among formerly homeless adults with mental disorders. *Psychiatric Rehabilitation Journal*, 38(1), 81– 87. <https://doi.org/10.1037/prj0000101>
- Perusco, M. (2010). Social Inclusion and Chronic Homelessness. *Parity*, 23(4), 38-39.
- Rubenstein, E. (1992). Homelessness and value: A stopping point or way of life? *Vital Speeches of the Day*, 401-404.
- Sara Brallier, S. S. (2024). Rational Choice? Choosing the Street over the shelter. *Journal of Social Distress and Homelessness*. doi:<http://doi.org/10.1080/10530789.2024.2379162>

Scott, J. (2000). Rational Choice theory: <https://doi.org/10.4135/9781446218310>.

https://www.researchgate.net/publication/259872468_Rational_Choice_Theory

Suzuki, Y. (2016). Reducing Homelessness in Japan: Government and NGO cooperation. *Asian Social Work and Policy Review*, 10(1), 76-89 .

Wasserman, J. (2010). At Home on the Street: People, Poverty & Hidden Culture of Homelessness.

Wright, J. (1989). Address unknown: Homelessness in contemporary America. *Society*, 26(6), 45-53.

АХБ. (2019). *Иргэний улсын бүтгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй, оршин суугаа газрын тодорхой хаяггүй, иргэний бичиг баримтгүй иргэдийг бүртгэлжүүлэх арга зам*. Улаанбаатар.

Баянмөнх. Л, Сүмжидмаа Т, Туяа С. (2023). Орон гэргүй болох шалтгааныг судлах нь. *Нийгмийн ажил сэтгүүл*, 64-69.

Нарантулга Б. (2022). *Нийгмийн халамжийн бодлогын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөө*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Эрдэнэчимэг Ө, Мөнхжаргал. Б, Навч Т. (2024). Гэр оронгүйдэл, түүний шалтгаан: Улаанбаатар хотын жишээгээр. *Монголын хүн амын сэтгүүл, Дугаар 34*, 130.